

2026.02.10

**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ
ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн тав дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна”, Долдугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”¹ гэж тус тус заасан.

Эдгээр заалт нь төрөөс үндэсний өв соёл, уламжлалт мал аж ахуй, тэдгээртэй салшгүй холбоотой соёлын үнэт зүйлсийг хамгаалах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Мөн “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай”² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны зарлиг, “Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай”³ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 59 дүгээр тогтоолоор морин хуурыг үндэсний хөгжмийн зэмсэг, соёлын өвийн хувьд дэмжих төрийн бодлогын баримт бичгүүд батлагдсан.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль нь анх 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд Монгол Улсын түүх, соёл, нийгмийн амьдралд чухал ач холбогдолтой баяр, тэмдэглэлт өдрүүдийг хуульчилсан байдаг.

Гэвч тус хуулийн 5 дугаар зүйлд Монголын уламжлалт мал аж ахуйн соёлын бэлгэ тэмдэг болсон тэмээ, үндэсний хөгжмийн язгуур зэмсэг болох морин хууртай холбоотой тусгай тэмдэглэлт өдрүүд тусгагдаагүй байна.

Иймд дээрх Үндсэн хуулийн заалтууд, төрийн бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн “Монгол тэмээний өдөр”, “Морин хуурын өдөр”-ийг хуульчлан тогтоох зорилгоор Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах шаардлага үүсэж байна.

1.2. Нийгэм, эдийн засаг, соёлын практик үндэслэл

Монгол Улсын уламжлалт мал аж ахуй нь олон мянган жилийн туршид монголчуудын амьдралын хэв маяг, соёл иргэншлийн суурь болж ирсэн бөгөөд өнөөдөр ч үндэсний эдийн засгийн чухал салбар хэвээр байна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 09 дүгээр зарлиг.

³ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 59 дүгээр тогтоол.

Манай улсын хос бөхт тэмээг “Монгол тэмээ” хэмээн олон улсад нэрлэдэг нь монголчуудын соёлын онцлог, бахархлыг илэрхийлдэг. Дэлхий дахинд буй хос бөхт тэмээний дөрөвний нэг орчим нь Монгол Улсад нутаглаж байгаа нь уг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх бодлогын ач холбогдлыг харуулж байна.

Сүүлийн хорин жилийн хугацаанд тэмээн сүргийн тоо толгой мэдэгдэхүйц өссөн нь малчдын хөдөлмөр, төрийн бодлогын үр дүн бөгөөд энэ өсөлтийг соёлын бодлогоор дэмжих шаардлагатай.

Иймд өвлийн улиралд буюу 1 дүгээр сарын 24-ний өдрийг “Монгол тэмээний өдөр” болгон тэмдэглэх нь тэмээтэй холбоотой уламжлалт мэдлэг, соёлыг сурталчлах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Морин хуур нь монголчуудын язгуур хөгжмийн зэмсэг бөгөөд XIII–XIV зууны үеийн түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн, ардын дуу, туульс, зан үйлтэй салшгүй холбоотой соёлын өв юм. 2008 онд ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн⁴ нь морин хуурын дэлхий дахины үнэ цэнийг баталж байна.

Жил бүрийн 6 дугаар сарын 7-ны өдөр нь үндэсний томоохон баяруудтай давхцахгүй, зуны аялал жуулчлалын улирал эхэлж буй үе тул “Морин хуурын өдөр”-ийг тэмдэглэхэд зохимжтой гэж үзэв.

Хоёр. Хуулийн төслийн зорилго

Энэхүү хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын уламжлалт мал аж ахуйн өв соёлын бэлгэ тэмдэг болсон тэмээ, үндэсний хөгжмийн язгуур зэмсэг морин хуурыг төрөөс онцгойлон дэмжих, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлд нэмэлт оруулж, Монгол Улсад нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрүүдийн нэр төрөл, огноог өргөтгөн тогтоох харилцааг зохицуулна.

Тодруулбал:

- Жил бүрийн 1 дүгээр сарын 24-ний өдрийг “Монгол тэмээний өдөр” болгон тэмдэглэх;
- Жил бүрийн 6 дугаар сарын 7-ны өдрийг “Морин хуурын өдөр” болгон тэмдэглэхээр тус тус хуульчлах юм.

Эдгээр өдрүүдийг хуульчлан тогтоосноор төр, орон нутгийн байгууллага, соёлын байгууллагууд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийн оролцоотойгоор соёл, сурталчилгаа, танин мэдэхүйн шинжтэй арга хэмжээг зохион байгуулах эрх зүйн үндэс бүрдэнэ.

⁴ Ө.Хэрлэн, “Монгол тэмээний өдөр”, “Морин хуурын өдөр”-ийг нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдөр болгохтой холбогдох гадаад улсуудын туршлага, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, 2026 он.

Хуулийн төслийн зохицуулалт нь иргэн, хуулийн этгээдэд нэмэлт үүрэг, хориг, хязгаарлалт тогтоохгүй бөгөөд зөвхөн соёлын бодлогын хүрээнд тэмдэглэлт өдрүүдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндэсний өв соёл, уламжлалт мал аж ахуй, оюуны өвийг хамгаалах төрийн үүрэг бодитоор хэрэгжихэд дэмжлэг үзүүлнэ.

Хоёрдугаарт, тэмээ, морин хууртай холбоотой уламжлалт мэдлэг, ур чадвар, зан үйл, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, түгээн дэлгэрүүлэх боломж нэмэгдэж, соёлын өвийн хадгалалт, өвлүүлэлт сайжирна.

Гуравдугаарт, иргэдийн үндэсний бахархал, эх оронч үзэл, соёлын дархлаа бэхжиж, хүүхэд, залуучуудад үндэсний өв соёлоо танин мэдэх, хайрлан хамгаалах ухамсар төлөвшинө.

Дөрөвдүгээрт, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, дотоодын болон гадаадын жуулчдад зориулсан соёлын арга хэмжээ тогтмолжин, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Тавдугаарт, хуулийн төсөл нь улсын төсөвт шууд дарамт учруулахгүй бөгөөд холбогдох арга хэмжээг салбарын байгууллагуудын батлагдсан төсөв, төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.

Эдийн засгийн нөлөөлөл

Хуулийн төсөл хэрэгжсэнээр соёлын бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлал, гар урлал, үйлчилгээний салбарт нэмэлт эрэлт бий болж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, уран бүтээлчид, малчдын орлого нэмэгдэх бодит боломж бүрдэнэ. **Тухайлбал**, “Монгол тэмээний өдөр”-ийг тэмдэглэхтэй холбоотойгоор тэмээний ноос, ноолуур, арьс шир, гар урлалын бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэх, орон нутагт зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, фестивалиудын хүрээнд үйлчилгээний орлого өсөх хандлага ажиглагдана.

“Морин хуурын өдөр”-ийн хүрээнд үндэсний хөгжмийн тоглолт, наадам, уралдаан, сургалт, үзэсгэлэн зохион байгуулагдсанаар соёлын байгууллага, уран бүтээлчид, хөгжмийн зэмсэг урлаачид, аялал жуулчлалын компаниудын орлого нэмэгдэнэ.

Дунд хугацаанд эдгээр арга хэмжээ нь соёлын аялал жуулчлалын тогтвортой бүтээгдэхүүн бий болгох, жуулчдын дундаж зарцуулалтыг өсгөх, улмаар татварын орлогын суурийг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзлээ.

Төсөв, санхүүгийн нөлөөллийн ерөнхий үнэлгээ

Хуулийн төсөл нь шинээр байгууллага байгуулах, орон тоо нэмэх, тогтмол өндөр зардал шаардах зохицуулалт агуулахгүй.

Эхний жилд улсын хэмжээнд мэдээлэл, сурталчилгаа, арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай зардлыг соёлын салбарын батлагдсан төсөв, орон нутгийн төсөв, ивээн тэтгэгч, хамтын ажиллагааны эх үүсвэрээр шийдвэрлэх боломжтой.

Эдгээр зардлыг салбарын байгууллагуудын одоогийн төсөвт багтаах, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ашиглах замаар шийдвэрлэх боломжтой бөгөөд улсын нэгдсэн төсөвт мэдэгдэхүйц ачаалал үүсгэхгүй.

Тав. Хууль тогтоомжийн уялдаа

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн үзэл баримтлал, зорилготой нийцэж байна.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, тухайлбал ЮНЕСКО-ийн “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц”-ийн зорилго, зарчимтай бүрэн нийцнэ.

Энэхүү хуулийн төслийг баталсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох шаардлага үүсэхгүй болно.

Зургаа. Хэрэгжилтийг хангах арга хэмжээ

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө “Монгол тэмээний өдөр”, “Морин хуурын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой арга хэмжээг тусгах;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд тухайн өдрүүдэд орон нутгийн онцлогт нийцсэн соёл, урлаг, танин мэдэхүйн арга хэмжээ зохион байгуулах;
- Соёлын байгууллага, мэргэжлийн холбоод, уран бүтээлчид, малчдын холбоо, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- Хүүхэд, залуучуудад зориулсан сургалт, уралдаан, үзэсгэлэн, тоглолт, танин мэдэхүйн хөтөлбөр хэрэгжүүлэх.

Долоо. Хуулийн төсөл Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль, тогтоомж байгаа эсэх талаарх санал

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хуультай нийцсэн байна.

Энэхүү хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжилтийн зохион байгуулалт

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд салбарын байгууллагуудын батлагдсан төсөв, орон нутгийн төсөв, ивээн тэтгэгч байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг ашиглана.

Жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийг батлах явцад соёлын салбарын хүрээнд эдгээр өдрүүдийг тэмдэглэхтэй холбоотой зардлыг нэгтгэн төлөвлөж, үр ашигтай, давхардалгүй байдлаар зохион байгуулна.

Хэрэгжилтийн явц, үр дүнг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дүгнэж, шаардлагатай тохиолдолд арга хэмжээний цар хүрээ, зохион байгуулалтын хэлбэрийг сайжруулах санал боловсруулна.